



**БАТЛАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭД САЙД,
ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ,
ХЯНАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАХ
ХОРООНЫ ДАРГА**

A handwritten signature in black ink, likely belonging to J. Jolmon.

Ж.ЦОЛМОН

ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2011-2021

Улаанбаатар хот

2011 оны 5 дугаар сарын 26

ГАРЧИГ

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	4
Хорт хавдрын өвчлөлийн өнөөгийн байдал, цаашдын төлөв	4
Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны өнөөгийн байдал	5
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2011-2021	8
Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ	9
Түншлэлийн стратеги	9
“Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2011-2021”-ний хүрээ	11

ТОВЧЛОЛ

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
АУХ	Анагаах ухааны хүрээлэн
АЭМГ	Аймгийн эрүүл мэндийн газар
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ДНЭ	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДЭМН	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл
ЗГХА-ЭМГ	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар
ЗГТА-ЦЭА	Засгийн газрын тохируулагч агентлаг-Цөмийн энергийн газар
ЗҮӨХ	Зан үйлийг өөрчлөх харилцаа
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
ММСС	Монголын мянганы сорилтын сан
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХЭН	Монголын хөнгөвчлөх эмчилгээний нийгэмлэг
МЭЭН	Монголын эс судлаач эмч нарын нийгэмлэг
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМХ	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
ОУАЭА	Олон улсын атомын энергийн агентлаг
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХБӨ	Халдварт бус өвчин
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

I. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хорт хавдрын өвчлөлийн өнөөгийн байдал, цаашдын төлөв

Монгол Улсад сүүлийн 10 жилийн байдлаар хорт хавдрын шинээр бүртгэгдэж буй тохиолдлын тоо тогтмол өссөөр 2010 оны байдлаар 4466 шинэ тохиолдол бүртгэгдэж, тэдгээрийн 60 орчим хувь нь нас баржээ. Хорт хавдраас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын шалтгаан дунд 2 дугаарт бичигдэж байна. Өөрөөр хэлбэл Монголд нас барж буй 5 хүний нэг нь хорт хавдрын улмаас нас барж байна.¹

Сүүлийн 10 жилийн байдлаар нийт тохиолдлын дотор дараах таван байрлалын хорт хавдар зонхилж байна. Үүнд: элэг (37.4%), ходоод (14.8%), уушги 9.2%), улаан хоолой (8.2%), умайн хүзүү (7.5%). Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэйчүүдийн дунд уруул, ам, залгиурын хорт хавдар 5 дугаарт, харин эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний хорт хавдар 2 дугаарт ордог. Үүний зэрэгцээ хөхний өмөнгийн тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.¹

Хорт хавдрын шинэ тохиолдол, нас баралтын зэрэгцээгээр нийт хүн амын дундах хорт хавдрын өвчлөлийн тархалт нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2000 онд 100000 хүн амд хорт хавдрын тархалт 283.6, шинэ тохиолдол 119.4, нас баралт 92.3, байсан бол 2009 онд 437.9, 153.0, 116.7, болж тус тус нэмэгджээ.¹

Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл

Хорт хавдрын өвчлөлд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйл, зан үйл хүн амын дунд түгээмэл байна. 2009 онд хийсэн “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох судалгаа”-гаар монгол 5 хүн тутмын 1 (26,4%)-д, 45-с дээш насны 2 хүн тутмын 1 (53,8%) - д халдварт бус өвчин (ХБӨ)-ний 3-аас дээш эрсдэл хавсран тохиолдож байна. Тодруулбал, нийт хүн амын 39,8% илүүдэл жинтэй ба үүнээс 12,5% нь таргалалттай байна. Монгол хүн хоногт 1.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын зөвлөмж хэмжээнээс 3.2 нэгжээр доогуур байна.

Мөн уг судалгаагаар эрэгтэйчүүдийн 39.7%, эмэгтэйчүүдийн 15,1% нь архиог хэтрүүлэн хэрэглэдэг дадалтай ажээ. Түүнчлэн хүн амын 27,7%, үүнээс эрэгтэйчүүдийн 48,0%, эмэгтэйчүүдийн 6,9% тамхи татдаг нь тогтоогджээ. Судалгаанд хамрагдсан 2 хүн тутмын 1 нь (42,9%) гэрийн орчинд, 3 хүн тутмын 1 нь (35,6%) ажлын байрандаа дам тамхидалтанд өртөж байна.

Мөн 2009 оны эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад нийт халдварт өвчний 17.2%-ийг вирус гепатит эзэлж байна. Нийт вирус гепатитийн дотор гепатит В - 10.9%, гепатит С - 1.9%-ийг тус тус эзэлж байна.

¹ Хавдар судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн алба, 2010 он

Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны өнөөгийн байдал

Хорт хавдраас сэргийлэх, хянах бодлого

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2007-2013”-ийн хүрээнд хорт хавдраас сэргийлэх, тэмцэх ажил бодлогын түвшинд зохицуулагдаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр 2008-2013” (цаашид дэд хөтөлбөр гэх)-ыг боловсруулан 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь хорт хавдраас сэргийлэх, хянах ажилд илүү анхаарал тавьж, ач холбогдол өгөхөд томоохон хувь нэмрийг оруулж байна. Мөн 2010 онд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах хороог эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан байгуулсан нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мөн оролцогч талуудын уялдааг сайжруулах, улмаар үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнтэй болгоход зохих хувь нэмэр оруулж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу 2009-2013 оны хугацаанд Монголын мянганы сорилтын сан (ММСС)-гийн санхүүжилтээр халдварт бус өвчин, үүний дотор зарим хорт хавдраас² сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь бодлогын түвшинд тус асуудалд анхаарал тавьж буйн илрэл юм. Үүний зэрэгцээ Монгол Улс Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-ийн ПАКТ³ хөтөлбөрийн жишиг наймдахь орноор сонгогдсон нь хорт хавдрын оношилгоо, эмчилгээний цаашдын хөгжилд багагүй хувь нэмрийг оруулах болно.

Хорт хавдраас сэргийлэх, хянах, тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, тулгамдаж буй асуудал

Хорт хавдраас сэргийлэх, хянах, хорт хавдартай өвчтөнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг голлон эрүүл мэндийн тогтолцоогоор дамжуулан хүргэж байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээний түвшинд дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн, хавдрын эрсдэлт зан үйлийг өөрчлөх, хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, эмчлэх, хавдартай өвчтнийг хянах, бүртгэх, зарим хавдрыг эрт илрүүлэх ажил хийгдэж байна. Хэдийгээр багагүй ажил хийгдэж буй боловч хүн амын эрүүл мэндийн талаарх, үүнд хорт хавдраас сэргийлэх мэдлэг, хандлага, дадал хангалтгүй⁴ байгаа тул өрх, сумын эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнуудын зан үйлийг өөрчлөх харилцаа (ЗҮӨХ)-ны ур чадварыг бэхжүүлэх бодит шаардлага байна. Хавдрын урьдал болон хорт хавдрыг эрт үеийн шинж тэмдгээр нь болон зохих түвшний сорил, шинжилгээгээр цаг алдалгүй илрүүлэх, даамжирсан хорт хавдартай өвчтөнд гэрээр үзүүлэх сувилгаа, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чадамжийг цогцоор бэхжүүлэх, хорт хавдрын бүртгэл мэдээллийг чанаржуулах ажил тулгамдсаар байна.

Хоёр дахь шатлал буюу аймгийн нэгдсэн эмнэлэг (АНЭ), дүүргийн эрүүл мэндийн нэгдэл (ДЭМН)-ийн түвшинд анхан шатнаас шилжүүлсэн, хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийн оношийг тодруулах нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хорт хавдартай өвчтний хими эмчилгээ хийх, даамжирсан хорт хавдартай өвчтөнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Түүнчлэн умайн хүзүүний хавдрын урьдал өвчнийг эсзүйн шинжилгээгээр оношилж,

² Умайн хүзүү, хөхний хорт хавдар

³ Programme of Action for Cancer Therapy

⁴ Хавдрын тусламж, үйлчилгээний үнэлгээ, ХСҮТ, 2008 он

эмчилж байна. Мөн дараагийн шатлалын тусламж, үйлчилгээ шаардлагатай хорт хавдартай өвчтнийг шилжүүлэх асуудлыг хариуцаж байна. Цаашид бүх төрлийн хавдрын эсзүй, эдзүйн шинжилгээний чадамжийг бэхжүүлэх, хими эмчилгээг хийх нөхцөл, боломжийг сайжруулах, хавдрын тасгийг нэгдсэн эмнэлгийн бүтцэд бий болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, хорт хавдрын бүртгэл мэдээллийг чанаржуулах, хавдрын эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх харилцааг явуулах, энэ чиглэлээр сум, өрхийн эмнэлгүүдэд арга зүйн тусламж үзүүлэх чадварыг бэхжүүлэх асуудал тулгамдсаар байна. Мөн дэд хөтөлбөрийн орон нутагт хэрэгжих үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт үнэлгээг сайжруулах хэрэгцээ байна.

Гурав дахь шатлал буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, клиникийн нэгдсэн эмнэлгийн түвшинд аймаг, дүүргээс шилжүүлсэн хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийн оношийг эцэслэн тогтоох, мөн хорт хавдартай өвчтөнд өмнөх шатлалд байхгүй, хорт хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээг хийх асуудлыг шийдвэрлэж байна. Мөн тухайн шатлалд тусламж, үйлчилгээг авсан өвчтнийг нэг, хоёрдахь шатлалын хяналт, хөнгөвчлөх эмчилгээнд шилжүүлж, хавдрын нарийн мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж байна.

Бүдүүн-шулуун гэдэсний ба бөөр, шээс ялгаруулах замын хавдрын зарим хагалгаа Улсын клиникийн төв эмнэлгийн бүдүүн-шулуун гэдэсний болон бөөрний мэс заслын мэс заслын тасагт, мэдрэлийн гаралтай хавдрын мэс заслын эмчилгээ Шастины нэрэмжит клиникийн нэгдсэн 3-р эмнэлгийн мэдрэлийн мэс заслын тасагт, хүүхдийн зарим хавдрын мэс заслын эмчилгээ Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хүүхдийн мэс заслын тасгуудад (ерөнхий, нүд, бөөр) тус тус хийгдэж байна. Үүнээс бусад бүх байрлалын хавдрын мэс заслын эмчилгээ Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-д хийгддэг.

ХСҮТ нь хорт хавдраас сэргийлэх, хянах болон хорт хавдрын тусламж үйлчилгээний бодлогыг мэргэжлийн түвшинд боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцаж байна. Үүний зэрэгцээ хорт хавдрын оношилгоо болон мэс засал, хими, туяа, хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр гуравдахь шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, хорт хавдрын оношилгоог хэт авиа, рентген, уян дуран, компьютер томографи зэрэг дүрс оношилгооны аргуудыг ашиглан хийхийн зэрэгцээгээр эсзүй, эдзүйн шинжилгээгээр хавдрын гарал үүслийг тодорхойлж, хавдрын маркер тодорхойлох, иммуногистохими, экспресс эдзүйн шинжилгээ зэрэг аргуудыг нэвтрүүлж эхлээд байна.

ХСҮТ нь хэвтэн эмчлүүлэх 190 ортой ба үүний 21 нь өдрийн эмчилгээний зориулалттай. Стационар нь мэс заслын клиник, мэс заслын бус клиник гэсэн үндсэн 2 хэсэгт хуваагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Мэс заслын клиник нь ерөнхий мэс засал, эрчимт эмчилгээ, элэг, цөс, нойр булчирхайн мэс засал, эмэгтэйчүүдийн мэс заслын тасгуудтай. Тус клиник жилдээ 2500 орчим өвчтөнд хавдрын мэс заслын тусламжийг үзүүлдэг ба сүүлийн жилүүдэд эрхтэн хадгалах, судас залгах бичил болон дурангийн мэс засал, радио хяналтат мэс ажилбаруудыг шинээр нэвтрүүлэн, үр дүнтэй хийж байна.

Мэс заслын бус клиник нь туяа, хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасгуудтай. Туяа эмчилгээний тасаг нь энэ төрлийн эмчилгээг хийдэг, улсын хэмжээний ганц нэгж бөгөөд кобальт-60 үүсгүүртэй зайн болон дотуур туяа эмчилгээний аппаратаар туяа эмчилгээг хийдэг. Хими эмчилгээнд одоогоор 10 орчим төрлийн хими эмчилгээний эм бэлдмэлийг дангаар болон хослуулсан аргаар хийж байгаа ба паклитаксол, оксалиплатин, этапозид, эпирубицин зэрэг химийн шинэ эмийг жил бүр бага багаар эмнэлзүйд нэвтрүүлж байна. Хөнгөвчлөх эмчилгээний 16 ортой тасаг нь хорт хавдрын улмаас эмчилгээгүй болж, амьдралын төгсгөлийн шатанд орсон өвчтөн болон түүний гэр бүлийнхэнд өвдөлт

намдаах, өвчтний зовиур шаналгааг багасгах эмийн эмчилгээний зэрэгцээ нийгэм, сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хөнгөвчлөх эмчилгээний их эмч, сувилагчаас гадна хоол зүйч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч оролцсон багийн үйл ажиллагаагаар үзүүлж буйгаараа онцлог юм.

Эрүүл мэндийн гуравдах шатлалын тусламж, үйлчилгээний зэрэгцээ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, хорт хавдрын судалгаа, бүртгэл мэдээллийг үндэсний түвшинд хариуцаж байна. Үүний зэрэгцээ хавдар судлаач болон эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмчийг резиденсийн сургалтаар бэлтгэх, хавдрын чиглэлээр дунд мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтаар мэргэшүүлэх, бусад мэргэжлийн эмч нарын мэргэжлийг хавдар судлалын чиглэлээр дээшлүүлэх ажлыг эрхэлдэг.

Цаашид ХСҮТ-ийн оношилгооны чадамжийг эдзүйн болон дүрс оношилгоо, лабораторийн чиглэлээр бэхжүүлэх, зарим шинэ технологийг нэвтрүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах шаардлага бий. Эмчилгээний чадамжийг дурангийн болон эрхтэн хадгалах, нөхөн сэргээх мэс заслын чиглэлээр хөгжүүлэх, элэг шилжүүлэн суулгах технологийг бий болгох асуудал тулгамдаж байна. Туяа эмчилгээнд шугаман хурдасгуурыг, мөн гурван хэмжээст төлөвлөлтийг зайн болон дотуур туяа эмчилгээнд нэвтрүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангах ажил хийгдэх хэрэгтэй. Хими эмчилгээний орчин үеийн эм, бэлдмэлийн төрлийг олшруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хими эмчилгээний аюулгүй орчинг сайжруулах бодит хэрэгцээ байна. Иймээс дээрхи чиглэлээр ажиллах эмч, эмнэлгийн ажилтны чадавхийг цогцоор, үе шаттайгаар, багаар нь сайжруулах асуудал нэн чухлаар тавигдана. Түүнчлэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний багийг бэхжүүлэх, түүгээр дамжуулан анхан ба хоёрдах шатлалын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний мэргэжилтнийг бэлтгэх, арга зүйгээр хангах ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Мөн оношилгоо, эмчилгээний чиглэл тус бүрт мэдээлэл, харилцааны технологийг ашиглах явдлыг өргөжүүлэхийг цаг үе шаардаж байна.

Хорт хавдрын судалгааг үндэсний тэргүүлэх чиглэлийн дагуу эрчимжүүлэх, судалгааг санхүүжүүлэх оновчтой арга замыг бүрдүүлэх, судлаачдыг бэлтгэж, чадавхийг бэхжүүлэх ажил хүлээгдсээр байна. Хорт хавдрын бүртгэл, мэдээллийг гуравдах шатлалын төв, эмнэлгүүд, мөн эмгэг судлалын төв хоорондоо солилцох, мэдээлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Иймээс хорт хавдрын бүртгэл, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх, гуравдугаар шатлалын бусад төв, эмнэлгийн мэдээллийг ХСҮТ-д нэгтгэх ажлыг сайжруулах хэрэгцээ байна. Мөн хорт хавдрын бүртгэл, мэдээллийн эмнэлэгт суурилсан өнөөгийн тогтолцоог хүн амд суурилсан хэлбэрт шилжүүлэх шаардлагатай.

II. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2011-2021

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа: 1) хорт хавдрын өвчлөл, нас баралтын сүүлийн арван жилийн статистикийн мэдээнд дүн шинжилгээ хийж, 2) “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2005-2013”, 3) “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр 2008-2013”-ийн баримт бичиг, 4) ДЭМБ-ын “Хорт хавдрын хяналт: мэдлэгийг ажилд нэвтрүүлэх. Үр дүнтэй хөтөлбөр боловсруулах” цуврал зургаан удирдамж⁵, 4) ОУАЭА-ийн ПАКТ хөтөлбөрийн техникийн ажлын хэсэгтэй хамтарч хорт хавдрын өвчлөл, нас баралт, тусламж, үйлчилгээний байдалд хийсэн үнэлгээний дүн зэргийг ашигласан болно. Үүний зэрэгцээ ДЭМБ-ын зөвлөх, профессор Жан Стернсворд, профессор Давид Родер нарын өгч байсан санал, зөвлөгөөг тусгасан болно. Мөн стратеги төлөвлөгөөг ХСҮТ-ийн нийт эмч нарын дунд хэлэлцүүлсэн.

Стратеги төлөвлөгөө нь дараах зорилготой: I) Хорт хавдрын гуравны нэгээс сэргийлэх, II) Бүх хавдрын гуравны нэгийг нь эрт илрүүлсний үндсэнд эмчлэх, III) Эмчлэх боломжгүй хожуу үедээ илэрсэн хавдартай хүмүүсийн гуравны хоёрыг нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулах. Стратеги төлөвлөгөө нь үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: 1) Урьдчилан сэргийлэлт, 2) Эрт илрүүлэлт 3) Оношилгоо ба эмчилгээ 4) Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг 2011-2021 он хүртэлх 10 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд: дархлаажуулалтаар сэргийлэх боломжтой зонхилон тохиолдох хоёр байрлалын хавдраас сэргийлэх, хорт хавдрыг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлийг холбогдох эрүүл мэндийн бусад хөтөлбөрийн хүрээнд бууруулах зорилтыг дэвшүүллээ. Дээрхи зорилтод хүрэхийн тулд гепатит В, хүний папиллома вирусээс дархлаажуулах, хүн амын дунд оршиж буй хорт хавдрын эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх үйл ажиллагааг тусгасан.

Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд: хорт хавдрын урьдал өвчин болон хорт хавдрын эрт үеийн оношилгоог сайжруулах зорилтыг дэвшүүллээ. Тус зорилтод хүрэхийн тулд зарим хорт хавдрын эрт үед илрэх шинж тэмдгийн талаарх мэдээллийг хүн амд хүргэх, илэрсэн тохиолдолд цаг алдалгүй эрүүл мэндийн байгууллагад ханддаг болгох, тэдгээр байгууллагын хавдрын урьдал өвчнийг болон хорт хавдрыг эрт илрүүлэх чадамжийг сайжруулах үйл ажиллагаа тусгагдсан.

Бүрэлдэхүүн 3-ын хүрээнд: хорт хавдрын оношилгоо, эмчилгээний орчин үеийн аргыг шинээр нэвтрүүлэх, одоо байгаа оношилгоо, эмчилгээний чадамжийг олон улсын жишигт хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүллээ. Тус зорилтод хүрэхийн тулд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ХСҮТ болон бусад холбогдох төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, клиникийн эмнэлгийн хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чадамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тусгасан.

Бүрэлдэхүүн 4-ийн хүрээнд хорт хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээг олон улсын жишигт хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүллээ. Тус зорилтод хүрэхийн тулд анхан болон хоёрдах шатлалд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тусгасан.

⁵ WHO, Cancer Control, Knowledge into Action. WHO Guide for Effective Programmes: Policy and Advocacy; Planning; Prevention; Early Detection; Diagnosis and Treatment; and Palliative Care, 2007.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт нь эрүүл мэндийн салбарын өнөөгийн тогтолцоонд тулгуурлаж, цаашид хийгдэж болох бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтөд цаг тухайд нь зохицуулагдана.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй дэмжлэгт орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг явуулах, мөн төлөвлөгөөг эрүүл мэндийн цаг үеийн бодлогод нийцүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэх, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг Эрүүл мэндийн яам (ЭМЯ) хариуцна. Үүний зэрэгцээ ЭМЯ дараа дараагийн халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр болон түүний хүрээнд хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх ажлыг тус стратеги төлөвлөгөөтэй уялдуулна. ЭМЯ-ны харьяа ХСҮТ нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, явцын хяналтыг тавьж, үр дүнг тайлагнана. Үүний зэрэгцээ төлөвлөгөөнд тусгагдсан гуравдах шатлалын түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ арга, технологийг нэвтрүүлэх, хорт хавдрын бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бэхжүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх, тархвар зүйн судалгаа, эрдэм шинжилгээг шинэ түвшинд гаргах, хавдар судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх ажлыг ХСҮТ хариуцна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар (ЗГХА-ЭМГ)-ын холбогдох албад хорт хавдраас сэргийлэх зан үйлийг өөрчлөх харилцаа (ЗҮӨХ)-г явуулах, хорт хавдрын бүртгэл, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх, эмч, мэргэжилтний чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажиллана.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар (ЭМГ), дүүргийн ЭМН хорт хавдраас сэргийлэх, тусламж, үйлчилгээний үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүртгэл, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэхэд гардан оролцоно. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үүнд хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэхэд үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Сум, өрхийн эмнэлэг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, анхан шатанд бүртгэх, тайлагнах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ.

Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), аймгийн ЭМГ, дүүргийн ЭМН, сум, өрхийн эмнэлэг нь гепатит В, хүний папилома вирусийн халдвараас дархлаажуулах ажлыг хариуцна.

Түншлэлийн стратеги

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд дэвшүүлсэн зорилго, зорилтуудад хүрэхийн тулд салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжиж, холбогдох олон улсын байгууллагатай түншлэлийг бэхжүүлж, мөн төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог ханган ажиллана. Энэхүү түншлэл нь дээр дурдсан удирдлага, зохион байгуулалтын тогтолцоонд суурилна.

Засгийн газрын тохируулагч агентлаг – Цөмийн энергийн агентлаг (ЗГТА-ЦЭГ) нь хавдрын өвөрмөц эмчилгээ болох туяа эмчилгээний чанар, цацрагийн аюулгүйн ажиллагаа, хамгаалалтын хөндлөнгийн хяналт тавих, энэ чиглэлийн олон улсын

байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Ажлын байран дахь хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), түүний орон нутгийн салбар, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага, үүнд мэргэжлийн нийгэмлэг, сан, холбоо, компани мөн олон нийт, хувь хүмүүстэй хавдраас сэргийлэх, хянах, оношлох эмчлэх бүх чиглэлийн үйл ажиллагаанд түншилнэ. Хүн амыг хавдрын эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрт илрүүлэх ажилд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг татан оролцуулах, хамтран ажиллахад хүчин чармайлт гаргана.

ОУАЭА-ийн ПАКТ хөтөлбөр нь хорт хавдрын туяа эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, инженер техникийн ажилтны чадавхийг бэхжүүлэхэд гол түнш байх болно. МСС-ийн эрүүл мэндийн төсөлтэй хорт хавдрын бүртгэл, мэдээлэл, эргэн дуудах тогтолцоог бэхжүүлэх, умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэлтийн чиглэлээр хамтран ажиллана. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ДЭМБ-аас мэргэжил, арга зүйн дэмжлэгийг цаг тухайд нь авахад анхааран ажиллана. ХСҮТ-ийн түнш байгууллагууд болох гадаадын хавдар судлалын төвүүд, их сургууль, эмнэлэг, төрийн бус байгууллагатай эмч, мэргэжилтнийг солилцох, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үргэлжлүүлэн хамтран хийнэ.

“Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2011-2021”-ний хүрээ

ЗОРИЛГО I: ХОРТ ХАВДРЫН ГУРАВНЫ НЭГЭЭС СЭРГИЙЛЭХ					
БҮРЭЛДЭХҮҮН 1: УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ					
Зорилт	Үйл ажиллагаа	Хүлээгдэж байгаа дүн үр, шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1.1. Дархлаажуулалтаар сэргийлэх боломжтой зонхилон тохиолдох хоёр байрлалын хавдраас ⁶ сэргийлэх.	1.1.1. Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд нярай хүүхдийг В гепатитийн эсрэг дархлаажуулалтад хамруулна.	- Нийт шинээр төрсөн нярай хүүхдийг 100% дархлаажуулалтад хамруулсан байна. - Элэгний анхдагч хавдрын 40%-иас сэргийлнэ.	2011-2021	ЭМЯ ХӨСҮТ	НЭМГ ДЭМН АЭМГ АНЭ Нийслэлийн амаржих газар
	1.1.2. Гепатит В вирусийн халдвар авах өндөр эрсэлтэй нөхцөлд ажилладаг эмнэлгийн ажилтныг дархлаажуулалтад хамруулна.	- Заагдсан эмнэлгийн ажилтан 100% дархлаажуулалтад хамрагдсан байна. - Элэгний анхдагч хавдрын 40%-иас сэргийлнэ.	2011-2021	ЭМЯ ХӨСҮТ	АНЭ ДЭМН Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, эмнэлэг
	1.1.3. Бэлгийн харьцаанд орохоос өмнөх насны охидыг хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулна.	- Эмэгтэйчүүдийн дотор зонхилон тохиолддог умайн хүзүүний хорт хавдрын 70%-иас сэргийлэх	2011-2021	ЭМЯ ММСС ХӨСҮТ	НЭМГ ДЭМН АЭМГ АНЭ
1.2. Хорт хавдрыг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлийг холбогдох эрүүл мэндийн бусад хөтөлбөрийн ⁷ хүрээнд бууруулах.	1.2.1. Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлс, үүнд согтууруулах ундаа, тамхи, орчны болон мэргэжлийн таагүй нөлөөллийг бууруулах хууль эрхзүйн орчинг сайжруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулна.	- УИХ-ын гишүүдээс бүрдсэн дэмжих бүлэг бий болсон байна. - Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар холбогдох хуулиудад өөрчлөлт орсон байна.	2011-2021	ЭМЯ ХСҮТ	ЗГХА -ЭМГ НЭМХ ДЭМБ МСС
	1.2.2. Ажлын байрны болон мэргэжлийн таагүй нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг явуулна.	- Ажил олгогч эзэд, мэргэжлийн хяналтын байгууллагад зориулсан ажлын байран дах хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн нөлөө, үр дагавар, сэргийлэх талаар сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	2011-2021	ЭМЯ НХХЯ ХСҮТ	МАОЭНХ МХЕГ

⁶ Гепатит В вирусээс шалтгаалсан элэгний хорт хавдар, умайн хүзүүний хавдар

⁷ Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөр

	1.2.3. Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэхэд чиглэсэн ЗҮӨХ-г үндэсний хэмжээнд явуулах тогтолцоог бэхжүүлнэ.	- Хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх ЗҮӨХ-ны бодлого боловсрогдон, хэрэгжиж эхэлсэн байна. - ХСҮТ болон нийт ДЭМН, АЭМГ-т хавдраас сэргийлэх МСС-ны баг сургагдан бэлтгэгдсэн байна.	2011-2015	ХСҮТ ЗГХА-ЭМГ	НЭМХ ДЭМН АЭМГ
	1.2.4. Хорт хавдраас сэргийлэх талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулна.	- ЕБС-ийн сурагчдын дунд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлийн талаарх мэдлэг, хандлага, чадварыг тогтоох суурь болон харьцуулсан судалгааг явуулж, үр дүн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авсан байна. - Хүн амд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хорт хавдраас сэргийлэх мэдээллийг тогтмол өгөх механизм бүрдсэн байна.	2012-2017	ЭМЯ БСШУЯ ХСҮТ	Боловсролын хүрээлэн НЭМХ ДЭМБ ММСС МҮОНРТ Хэвлэл мэдээллийн байгууллага
	1.2.5 Хавдрын бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгоно.	- Эмнэлэгт суурилсан хавдрын бүртгэл, мэдээллээс хүн амд суурилсан бүртгэл мэдээллийн тогтолцоонд шилжсэн байна. - Умайн хүзүү, хөхний хавдрын эргэн дуудах тогтолцооны програм хангамжийг боловсруулж, эрүүл мэндийн тогтолцооны шатлал бүрд бүртгэх, тайлагнах тогтолцоог бүрдүүлсэн байна. - Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, лаборатори, эмнэл зүйн тусламж үйлчилгээний мэдээллийн сан үүсгэж, цахим сүлжээгээр ашигладаг болсон байна.	2012-2021	ЭМЯ УБЕГ ХСҮТ ММСС	ЗГХА-ЭМГ НЭМГ ДЭМН АЭМГ АНЭ
	1.2.6 Зонхилон тохиолддог хорт хавдрын тархвар зүйн болон эмнэл зүйн судалгааг хийх чадавхийг бэхжүүлнэ.	- Зонхилон тохиолдох 5-6 хорт хавдрын тархвар зүйн судалгаа хийгдсэн байна. - Хавдраас сэргийлэх, хянах бодлого, стратегийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсан байна. - Зонхилон тохиолдох 3-аас доошгүй хорт хавдрын чиглэлээр эмнэл зүйн туршилт судалгааг хийгдэж, үр дүнийг нь өдөр тутмын практикт нэвтрүүлсэн байна.	2011-2021	ХСҮТ АУХ	НЭМХ

ЗОРИЛГО II: БҮХ ХАВДРЫН ГУРАВНЫ НЭГИЙГ ЭРТ ИЛРҮҮЛСНИЙ ҮНДСЭНД ЭМЧЛЭХ					
БҮРЭЛДЭХҮҮН 2: ЭРТ ИЛРҮҮЛЭЛТ					
Зорилт	Үйл ажиллагаа	Хүлээгдэж байгаа дүн үр, шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
2.1. Хорт хавдрын урьдал өвчин болон хорт хавдрын эрт үеийн оношилгоог сайжруулах.	2.1.1 Зарим эрхтний ⁸ хорт хавдрын эрт үед илрэх шинж тэмдгийн талаарх мэдээллийг хүн ам, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарт хүргэж, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад цаг алдалгүй хандах дадлыг хэвшүүлнэ.	- Хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх зан үйлийг өөрчлөх харилцаа (ЗҮӨХ)-ны бодлого боловсрогдон, хэрэгжиж эхэлсэн байна. - Хүн амын зарим хорт хавдрын эрт үеийн шинж тэмдгийн талаарх мэдлэг, илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хандах хандлага сайжирсан байна. - Хөх, төмсөгний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор эмэгтэйчүүдийг хөхөө, эрэгтэйчүүдийг төмсөгөө өөрөө шалгах аргад сургана.	2011-2015	ХСҮТ	ЗГХА -ЭМГ НЭМГ ДЭМН АЭМГ Сум, өрхийн эмнэлэг ММСС МҮОНРТ Хэвлэл мэдээллийн байгууллага
	2.1.2. Эрүүл мэндийн салбарын, ялангуяа анхан шатны тусламж үйлчилгээний хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, эмчлэх цогц чадамжийг дээшлүүлнэ.	- Умайн хүзүү, хөх, амны хөндийн хорт хавдрын эрт илрүүлэлтийг эрүүл мэндийн анхан болон хоёрдах шатлалд сайжруулна. - 30-60 насны эмэгтэй бүр умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 3 жилийн давтамжтай хамрагддаг болсон байна. - Бусад, ялангуяа элэг, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэлтийг эрүүл мэндийн хоёрдах болон гурав дахь шатлалд сайжруулна. - Хавдар судлаачаас бусад мэргэжлийн эмч нарын хавдрын урьдал болон хорт хавдрын эрт илрэх шинж тэмдэг, авах арга хэмжээний талаарх мэдлэг, чадварыг сайжруулна. - Хэт авиан оношлогооны эмч нарын элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх ур чадвар сайжирсан байна.	2011- 2021	ЭМЯ ХСҮТ	ЗГХА -ЭМГ НЭМГ ДЭМН АЭМГ Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, эмнэлэг Сум, өрхийн эмнэлэг ММСС МҮОНРТ Хэвлэл мэдээллийн байгууллага

⁸ Эрт үед оношлох боломжтой хорт хавдрын байршил: хөх, умайн хүзүү, амны хөндий, хамар-залгиур, ходоод, арьс, давсаг, түрүү булчирхай, ретинобластома, төмсөг (WHO, Cancer Control, Knowledge into Action; WHO Guide for Effective Programmes, Early Detection, 2007).

		- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрийн хорт хавдрыг илрүүлэх, оношлох багаж хэрэгсэл, шаардлагатай урвалж бодис, тоног төхөөрөмжийн хүртээмж сайжирсан байна - Хорт хавдрын сэжигтэй үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал хооронд шилжүүлэх, оношийг тодруулах тогтолцоо оновчтой болсон байна.			
БҮРЭЛДЭХҮҮН 3: ХОРТ ХАВДРЫН ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ					
Зорилт	Үйл ажиллагаа	Хүлээгдэж байгаа дүн үр, шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
3. 1. Хорт хавдрын оношлогоо, эмчилгээний орчин үеийн аргыг шинээр нэвтрүүлэх, одоо байгаа оношлогоо, эмчилгээний чадамжийг олон улсын жишигт хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх.	3.1.1. Аймаг, дүүргийн эмнэлгийн хорт хавдрыг оношлох чадавхийг сайжруулна.	- Нийт аймаг, дүүргийн эмнэлгүүдэд умайн хүзүүний хорт хавдрын оношлогоонд эсзүйн арга хэрэглэгддэг болсон байна. - Бүсийн оношилгоо эмчилгээний төв (БООТ), Улаанбаатар хотын дүүргийн эмнэлгүүдэд хөхний хорт хавдрын оношлогоонд маммографийн арга хэрэглэгддэг болсон байна. - Нийт аймгийн нэгдсэн эмнэлгийн наад зах нь 50%, Улаанбаатар хотын нийт дүүргийн эмнэлгүүдэд хорт хавдрын оношлогоонд эдзүйн шинжилгээ хийдэг болсон байна. - Хэт авиан оношлогооны эмч нарын элэгний хорт хавдрыг оношлох ур чадвар сайжирсан байна. - Нийт аймаг, дүүргийн дүрслэл оношлогооны (дуран, рентген, КТГ) эмч нарын хорт хавдрыг оношлох ур чадвар сайжирсан байна. - Аймаг, дүүргийн нийт эмнэлгүүдийн лаборатори нь зарим хавдрын маркерийг тодорхойлдог болсон байна.	2011- 2021	ЭМЯ ХСҮТ ММСС	НЭМГ ДЭМН АЭМГ БООТ АНЭ
	3.1.2. Аймаг, дүүргийн эмнэлгийн бүтцэд хавдрын тасгийн байгуулж,	- Нийт аймаг, дүүргийн эмнэлэгт хавдар судлаач болон хөнгөвчлөхийн эмч, сувилагч, бүртгэлийн	2011-2013	ЭМЯ ХСҮТ	НЭМГ ДЭМН АЭМГ

	үйл ажиллагааг нь бэхжүүлнэ.	ажилтантай Хавдрын тасаг байгуулагдсан байна. - Аймаг, дүүргийн эмнэлгийн хавдрын тасаг хими эмчилгээг хийдэг, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна. - Нийт аймаг, дүүргийн эмнэлэг ХСҮТ-өөс зайн оношлогоогоор зөвлөгөө, тусламж авдаг болсон байна.			БОЭТ АНЭ
	3.1.3. Гуравдугаар шатлалын холбогдох төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлгийн хорт хавдрыг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулна.	- Бусад өвчин эмгэгийг оношлох явцад хорт хавдрыг оношилсон тохиолдолд бүртгэх, ХСҮТ рүү шилжүүлэх үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна. - Хорт хавдар оношлогдсон тохиолдолд багажийн болон эс, эдзүйн шинжилгээгээр тодруулах удирдамжтай болсон байна. - Нарийн мэргэжлийн эмч нарын хорт хавдрыг оношлох ур чадвар сайжирсан байна. - ХСҮТ-д хийгддэгээс бусад байрлалын ⁹ болон хүүхдийн хорт хавдрын бүртгэл сайжирч, цогц үргэлжилсэн эмчилгээг хамтран хийх мэргэжлийн уялдаа сайжирсан байна.	2011-2021	ЭМЯ ХСҮТ	Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, эмнэлэг ММСС
	3.1.4. ХСҮТ-ийн хорт хавдрыг оношлох, эмчлэх чадавхийг сайжруулна.	- Хорт хавдрын оношлогоо, эмчилгээ, сувилахуйн шаардлагатай стандарт, удирдамжийг олон улсын жишгийн дагуу боловсруулж, мөрддөг болсон байна. - Хорт хавдрын дүрслэл оношлогоонд техник технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хийж, КТГ, цахилгаан соронзон томографи, позитрон-эмиссион томографи нэвтрүүлсэн байна. - Дурангийн оношилгоо, эмчилгээний төв байгуулагдсан байна. - Эс, эдзүйн шинжилгээний чадавхийг бэхжүүлж, иммуногистохими зэрэг шинэ аргыг нэвтрүүлсэн байна.	2011-2021	ЭМЯ ХСҮТ	ЗГТА-ЦЭГ ОУАЭА ДЭМБ МЭЭН

⁹ Тархи мэдрэл, бүдүүн шулуун гэдэс, бөөр, шээсний замын хавдар

	- Нийт аймаг, дүүргийн эмнэлэгт зайн оношлогоогоор зөвлөгөө, тусламж өгдөг болсон байна. Мэс заслын эмчилгээнд орчин үеийн, дэвшилтэт технологийг, тухайлбал элэг шилжүүлэн суулгах, эрт үеийн хорт хавдрыг дурангийн мэс заслын аргаар авах, гол судасны хажуу дах тунгалгийн булчирхайг түүх, нөхөн сэргээх, бичил мэс заслыг нэвтрүүлж бэхжүүлсэн байна. - Элэгний мэс заслын төв байгуулагдсан байна. - Туяа эмчилгээг 4 хэмжээст технологид шилжүүлж, шугаман хурдасгуур аппарат суурилуулж, үүнд тулгуурласан туяа эмчилгээний орчин үеийн, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, цацрагийн хэмжилт, аюулгүй ажиллагаа, хамгаалалтын ОУАЗА болон бусад холбогдох олон улсын байгууллагын стандартыг бүрэн мөрддөг болсон байна. - Хими эмчилгээнд орчин үеийн, шинэ эм, бэлдмэлийг эмчилгээнд бүрэн нэвтрүүлж, мөн хими эмчилгээний аюулгүй орчныг бэхжүүлсэн байна. - Хавдрын дэмжих үйлчилгээ, үүнд сэтгэл засал, хоол эмчилгээ, нийгмийн тусламж үйлчилгээг болон нөхөн сэргээх эмчилгээг бэхжүүлж, олон улсын жишгийн дагуу боловсруулсан удирдамжийг боловсруулж, мөрддөг болсон байна. - Эмчилгээ, үйлчилгээн дэх цахим сүлжээний тогтолцоог бэхжүүлж, PACS-ийг бүрэн нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлсэн байна. - Эмч, мэргэжилтнүүд шинээр нэвтрүүлсэн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж, арга технологийг багаар ашиглах чадвартай болсон байна. - Шинээр нэвтрүүлсэн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй, найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хангах чадавхи бүхий баг бүрдсэн байна.			
--	--	--	--	--

ЗОРИЛГО III: ЭМЧЛЭГДЭХ БОЛОМЖГҮЙ, ХОЖУУ ҮЕ ШАТАНДАА БУЙ ХОРТ ХАВДАРТАЙ ХҮМҮҮСИЙН ГУРАВНЫ ХОЁРЫГ ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ

БҮРЭЛДЭХҮҮН 4: ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт	Үйл ажиллагаа	Хүлээгдэж байгаа дүн үр, шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
4.1. Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээг олон улсын жишигт хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх.	4.1.1 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, бэхжүүлнэ.	Хорт хавдрын хөнгөвчлөх, ялангуяа сэтгэл зүйн тусламж үйлчилгээний удирдамжийг олон улсын жишгийн дагуу боловсруулж, мөрддөг болсон байна. Нийт аймаг, дүүргийн эмнэлэгт байгуулагдах хавдрын тасаг нь 5-аас доошгүй хөнгөвчлөх эмчилгээний ортой байна. Нийт сум, өрхийн эмнэлэг хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх чадвартай болсон байна. Анхан болон хоёр дах шатлалын эмч, эмнэлгийн ажилчдын хөнгөвчлөх эмчилгээ, тусламж үйлчилгээний талаарх мэдлэг, чадвар, хандлага сайжирсан байна. Олон нийт, ялангуяа сайн дурынхан, төрийн бус байгуулагад тулгуурлан өвчтөн, тэдний гэр бүлийнхэн, асран хамгаалагчийг хөнгөвчлөх асаргаа, сувилгаанд сургадаг болсон байна. Өвдөлт намдаахад шаардлагатай опиоидийн эм, ялангуяа морфины хэрэглээ тогтвортой, бүрэн хангагдсан байна. ХСҮТ нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний эмч, сувилагч бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх энэ чиглэлээр зөвлөгөө өгөх мэргэжил, аргазүйн төв болсон байна.	2011 2021	ЭМЯ ХСҮТ	НЭМГ ДЭМН АЭМГ БОЭТ АНЭ Сум, өрхийн эмнэлэг МХЭН ДЭМБ ММСС